

**“ОЛОН УЛСЫН АВТОТЭЭВРИЙН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ  
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,  
БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН  
ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ  
МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ,  
БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗАМ ТЭЭВРИЙН ЯАМ  
ХООРОНДЫН ПРОТОКОЛ**

Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яам болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Зам, тээврийн яам цаашид “Талууд” гэх)

Хоёр улсын ард түмний найрсаг харилцаа, худалдаа, эдийн засгийн хөгжилд түлхэц үзүүлэх, хоёр улсын хооронд олон улсын авто замаар ачаа, зорчигч тээвэрлэх үйл ажиллагааг улам хөгжүүлэх зорилгоор 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан “Олон улсын автотээврийн харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” (цаашид “Хэлэлцээр” гэх)-ийг үндэслэн, дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов. Үүнд:

**1 дүгээр зүйл**

**Эрх бүхий байгууллага болон түүнээс эрх олгосон байгууллага**

Энэхүү протоколд заасан эрх бүхий байгууллага, түүнээс эрх олгосон байгууллага нь:

Монгол Улсын Эрх бүхий байгууллага нь Зам, тээврийн хөгжлийн яам Эрх олгогдсон байгууллага нь “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газар байна.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Эрх бүхий байгууллага нь Зам тээврийн яам. Эрх олгогдсон байгууллага нь Өвөр Монголын Өөртөө Засах Орон болон Шиньжан Уйгурын Өөртөө Засах Орны Зам харилцаа, тээврийн танхим байна.

Хэлэлцэн тохиролцогч нэг Талын дээр дурдсан эрх бүхий болон эрх олгогдсон байгууллагын нэрэнд өөрчлөлт орсон тохиолдолд өөрчлөлт орсноос хойш ажлын 5 хоногийн дотор хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий байгууллага, эсхүл эрх олгогдсон байгууллагад бичгээр мэдэгдэнэ.

**2 дугаар зүйл**

**Зөвшөөрлийн бичгийн ангилал, төрөл**

1.Зөвшөөрлийн бичгийг “Олон улсын тээвэрлэлт хийх тээврийн хэрэгслийн зорчих зөвшөөрөл” (цаашид “зорчих зөвшөөрөл” гэх) болон “Олон улсын тээвэрлэлт хийх тээврийн хэрэгслийн онцгой зөвшөөрөл” (цаашид “онцгой зөвшөөрөл” гэх) гэж ангилах бөгөөд эдгээр зөвшөөрлийн бичиг баримт нь тухайн жилдээ хүчинтэй байна.

2. Зорчих зөвшөөрөл нь А, А-С, В, С, D, G, H гэсэн 7 төрөлтэй байна:

- 1) А төрлийн зорчих зөвшөөрөл нь зорчигчийн тогтмол тээвэрлэлт хийх тээврийн хэрэгсэлд хэрэглэх бөгөөд жилдээ олон удаа хил нэвтрэхэд хүчинтэй;
- 2) А-С төрлийн зорчих зөвшөөрөл нь тогтмол тээврээр зорчигчийн ачааг тээвэрлэх тээврийн хэрэгсэлд хэрэглэх бөгөөд жилдээ олон удаа хил нэвтрэхэд хүчинтэй;
- 3) В төрлийн зорчих зөвшөөрөл нь зорчигчийн тогтмол бус тээвэрлэлт хийх тээврийн хэрэгсэлд хэрэглэх бөгөөд олгосон өдрөөс эхлэн 30 хоногийн дотор зөвхөн нэг удаа хил нэвтрэхэд хүчинтэй;
- 4) С төрлийн зорчих зөвшөөрөл нь байнгын ачаа тээвэрлэлт хийх тээврийн хэрэгсэлд хэрэглэх бөгөөд олгосон өдрөөс эхлэн 120 хоногийн дотор олон удаа хил нэвтрэхэд хүчинтэй;
- 5) D төрлийн зорчих зөвшөөрөл нь түр хугацааны ачаа тээвэрлэлт хийх тээврийн хэрэгсэлд хэрэглэх бөгөөд олгосон өдрөөс эхлэн 30 хоногийн дотор зөвхөн нэг удаа хил нэвтрэхэд хүчинтэй.
- 6) G төрлийн зорчих зөвшөөрөл (ирэх, буцах) нь гуравдагч улсаас, эсхүл гуравдагч улс руу тээвэрлэлт хийх тээврийн хэрэгсэлд хэрэглэх бөгөөд олгосон өдрөөс эхлэн 60 хоногийн дотор нэг удаа ирэх, буцахад хүчинтэй.
- 7) H төрлийн зөвшөөрлийн бичиг нь дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлт хийх тээврийн хэрэгсэлд хэрэглэх бөгөөд олгосон өдрөөс эхлэн 30 хоногийн дотор нэг удаа ирэх, буцахад хүчинтэй.

3. Онцгой зөвшөөрөл нь E, F гэсэн 2 төрөлтэй байна.

- 1) E төрлийн онцгой зөвшөөрөл нь хэлэлцэн тохиролцогч нэг Талын тээврийн хэрэгслийн оврын хэмжээ, бүрэн жин болон нэг тэнхлэг дээрх ачаалал нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын техникийн стандартад заасан ачаа тээвэрлэлтийн хэмжээнээс хэтэрсэн, эсхүл зам, тээврийн техникийн стандартад заасан хэмжээнээс хэтэрсэн, задалж болдоггүй ачааг тээвэрлэх тээврийн хэрэгсэлд хэрэглэх бөгөөд зөвхөн нэг удаа хил нэвтрэхэд хүчинтэй;
- 2) F төрлийн онцгой зөвшөөрөл нь аюултай ачааг тээвэрлэх тээврийн хэрэгсэлд хэрэглэх бөгөөд зөвхөн нэг удаа хил нэвтрэхэд хүчинтэй.

4. Зөвшөөрлийн бичгийн загварыг 1 дүгээр хавсралтаар тодорхойлов.

### 3 дугаар зүйл

#### Зөвшөөрлийн бичиг баримтын зохицуулалт

1. Зорчих зөвшөөрлийг харилцан солилцох хэлбэрээр олгох бөгөөд Хэлэлцэн тохиролцогч Талуудын эрх бүхий байгууллага болон эрх олгогдсон байгууллага Хэлэлцээрийн 18 дугаар зүйлд заасан хурлын үеэр дараа жилд

хэрэглэх зорчих зөвшөөрлийг харилцан адил байх зарчимд тулгуурлан тэнцүү тоогоор тогтоож, солилцох тодорхой хугацаа, газрыг хэлэлцэн тохиролцоно. Хоёр талын эрх олгогдсон байгууллага хэлэлцэн тохиролцсон тоогоор зорчих зөвшөөрлийг жил бүрийн сүүлчийн хагаст солилцож, дотоодын хууль тогтоомжид заасан шаардлага хангасан тээвэрлэгчид олгоно.

2. Зорчих зөвшөөрлийн тоо хүрэлцэхгүй болсон тохиолдолд тухайн Талын эрх олгогдсон байгууллага нь зорчих зөвшөөрөл нэмж авах хүсэлтээ нөгөө Талын эрх олгогдсон байгууллагад бичгээр гаргана. Нөгөө Талын эрх олгогдсон байгууллага нь уг хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор хариу өгнө.

3. Онцгой зөвшөөрлийг хүсэлт гаргах замаар авах бөгөөд бүрдүүлэх материалын жагсаалтыг хэлэлцэн тохиролцогч хоёр талын эрх бүхий байгууллага тодорхойлж, солилцоно. Хэлэлцэн тохиролцогч нэг Талын тээвэрлэгч нь өөрийн Талын эрх олгогдсон байгууллагаараа дамжуулан нөгөө талын эрх олгогдсон байгууллагад зөвшөөрөл авах хүсэлтээ бичгээр гаргана. Хүсэлтэд тээврийн маршрут, тээвэрлэлт гүйцэтгэх хугацаа, ачааны нэр, төрөл зэрэг мэдээллийг тусгаж, тээвэрлэгч, тээвэрлүүлэгчийн хооронд байгуулсан гэрээг хавсаргана.

Нөгөө Талын эрх олгогдсон байгууллага тухайн хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор өөрийн улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан үзэж хариу өгнө. Онцгой зөвшөөрөл олгохоор шийдвэрлэсэн тохиолдолд зөвшөөрлийг нөгөө Талын эрх олгогдсон байгууллагаар дамжуулан тээвэрлэгчид олгох, эсхүл зөвшөөрөл олгохоор шийдвэрлэсэн тухайгаа нөгөө Талын эрх олгогдсон байгууллагад мэдэгдэж, тээвэрлэгчид шууд олгож болно.

4. Зөвшөөрлийн бичиг нь Хэлэлцэн тохиролцогч Талуудын эрх бүхий байгууллага болон эрх олгогдсон байгууллагын тэмдэгтэй байх бөгөөд эрх олгогдсон байгууллагын удирдах албан тушаалтан гарын үсэг зурж, олгогч байгууллагын хариуцах хүн олгосноор хүчинтэй болно.

5. Хэлэлцэн тохиролцогч нэг Талын тээвэрлэгч хэлэлцээрийн 7 дугаар зүйлд заасан тээвэрлэлт гүйцэтгэх тохиолдолд тухайн Талын эрх олгогдсон байгууллага нь хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын эрх олгогдсон байгууллагад бичгээр урьдчилан мэдэгдэнэ.

#### 4 дүгээр зүйл

##### Зорчигчийн тогтмол тээвэрлэлтийн маршрут

1. Хэлэлцэн тохиролцогч Талуудын эрх бүхий байгууллага болон эрх олгогдсон байгууллагууд эрх тэгш, харилцан ашигтай байх зарчмыг үндэслэн хэлэлцээрийн 18 дугаар зүйлд заасан хурлын үеэр тээврийн маршруттай холбоотой асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

2. Хэлэлцэн тохиролцогч Талуудын эрх бүхий байгууллага болон эрх олгогдсон байгууллагууд нээхээр төлөвлөж буй зорчигчийн тогтмол тээвэрлэлтийн маршрут нээх судалгаа, тооцоо бүхий үндэслэл, үнэлгээ дүгнэлтийн талаарх баримт бичгийг хоёр талын холбогдох байгууллагаар хийлгэж болох бөгөөд дараагийн уулзалтаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

3. Хоёр Талын эрх олгогдсон байгууллага уулзалтаар зорчигчийн тогтмол тээвэрлэлтийн тээврийн маршрут нээхээр тохиролцсоноос хойш 60 хоногийн дотор тухайн тээврийн маршрутыг нээх тодорхой хугацаа, тээвэрлэгч, тээврийн хэрэгслийн тоо, эхлэх цэг, нэвтрэх боомт, дамжин өнгөрөх газар, дундын зогсоол хүрэх цэг, тээвэрлэлтийн давтамж, үнэ зэргийг албан бичиг солилцож тогтооно.

### 5 дугаар зүйл

Ачаа тээвэрлэлт болон зорчигчийн тогтмол бус тээвэрлэлтийн маршрут

1. Ачаа тээвэрлэлт болон зорчигчийн тогтмол бус тээвэрлэлтийг хоёр Талын эрх бүхий байгууллага тохиролцсоноос бусад тохиолдолд зарчмын хувьд маршрут хязгаарлахгүй гүйцэтгэнэ.

2. Хэлэлцэн тохиролцогч нэг Талын тээврийн хэрэгсэл хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт нэвтэрсний дараа хэлэлцэн тохиролцогч Талуудын эрх бүхий байгууллага, эсхүл эрх олгогдсон байгууллагуудын хооронд тохиролцсон тээврийн маршрутаар тээвэрлэлт гүйцэтгэнэ.

3. Тээвэрлэлтийн явцад зам тээврийн осол гарсан, байгалийн гамшиг зэрэг давагдашгүй хүчин зүйл тохиолдсоны улмаас тээврийн хэрэгсэл заасан тээврийн маршрутаар явах боломжгүй болсноос бусад тохиолдолд өөр замаар явж болохгүй бөгөөд хоёр Талын хэлэлцэн тогтсон зогсоолд тээврийн хэрэгслээ зогсоож, зорчигчдыг суулгаж, буулгах болон ачааг ачиж, буулгана.

### 6 дугаар зүйл

Бичиг баримт болон ялгах тэмдэг

1. Хэлэлцэн тохиролцогч нэг Талын тээврийн хэрэгслийн жолооч хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт зорчихдоо дараах бичиг баримтыг биедээ болон тээврийн хэрэгсэлдээ авч явна. Үүнд:

1) өөрийн улсын хүчин төгөлдөр жолооны үнэмлэх;

2) өөрийн улсын хүчин төгөлдөр гадаад паспорт, холбогдох виз болон хоёр улсын Засгийн газар хооронд байгуулсан хэлэлцээрээр тохиролцсон хүчинтэй хил нэвтрэх бичиг баримт;

3) зорчих зөвшөөрөл, эсхүл онцгой зөвшөөрөл; (Хэлэлцээрийн 8 дугаар зүйлд заасан тээврийн хэрэгсэлд хамаарахгүй);

4) зорчигчдын нэрсийн жагсаалт бүхий дагалдах хуудас, эсхүл ачааны дагалдах хуудас (дагалдах хуудасны загварыг 2 дугаар хавсралтаар тодорхойлов);

5) Хэлэлцээрийн 16 дугаар зүйлд заасны дагуу заавал даатгуулах даатгалд даатгуулсан гэрчилгээ;

6) тээврийн хэрэгслийн гэрчилгээ;

7) төхникийн аюулгүй байдлын хяналтын гэрчилгээ;

8) тээврийн хэрэгсэл, эсхүл зүтгүүр, хагас чиргүүлийн улсын дугаар.

2. Хэлэлцэн тохиролцогч Талуудын олон улсын авто замаар тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгсэл нь тухайн улсын таних тэмдэгтэй байна.

Монгол талын ялгах тэмдэг: MGL.

Хятад талын ялгах тэмдэг: CHN.

таних тэмдгийн загварыг 3 дүгээр хавсралтаар тодорхойлов.

## 7 дугаар зүйл

### Зорчигч тээвэрлэлт

1. Тээвэрлэгч нь хоёр улсын хооронд тогтмол болон тогтмол бус зорчигч тээвэрлэлтийг хэлэлцээрийн 4, 5 дугаар зүйлд заасны дагуу гүйцэтгэнэ.

2. Зорчигчийн тогтмол тээвэрлэлтэд зорчигчийн зорчих тасалбар хэрэглэнэ. Зорчигчийн тогтмол тээврийн тасалбарыг цахим хэлбэрээр олгохыг дэмжинэ.

3. Зорчигчийн тогтмол тээвэрлэлтэд хэрэглэх зорчигчийн зорчих тасалбарын үнийг хоёр талын эрх олгогдсон байгууллага хэлэлцэн тогтооно.

4. Хүүхдийн зорчих тасалбарын асуудлыг өөр өөрийн улсын холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

5. Зорчигчийн тогтмол тээврийн хэрэгслээр зорчиж байгаа зорчигчийн ачааг битүү бүхээг бүхий ачааны тээврийн хэрэгсэлд ачиж, зорчигчийн тогтмол тээврийн хэрэгслийг дагалдуулж явуулна.

6. Авто зогсоолын ажилтан зорчигчийн ачаанд хууль тогтоомжийн дагуу үзлэг шалгалт хийх бөгөөд сэжиг бүхий ачаа, тээшийг онгойлгон шалгаж болно Амархан шатах, дэлбэрэх зэрэг аюултай ачаа, зорчигчийн эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлэх болон ая тухтай байдлыг алдагдуулах зүйлс, хөдөлгөөний аюулгүй байдалд саад учруулах ачаа, тээшийг тээвэрлэх, биедээ авч тээврийн хэрэгсэлд орохыг хориглоно.

## 8 дугаар зүйл

### Ачаа тээвэрлэлт

1.Тээвэрлэгч нь хоёр улсын хоорондын байнгын болон түр хугацааны ачаа тээвэрлэлтийг Хэлэлцээрийн 6 дугаар зүйлд заасны дагуу гүйцэтгэнэ.

2.Байнгын болон түр хугацааны ачаа тээвэрлэлтийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ. Ачаа тээвэрлэлтийн үнийг тээвэрлэгч, тээвэрлүүлэгч харилцан тохиролцож тогтооно. Үнийг тогтоохдоо өөрийн улсын дотоодын хууль тогтоомжид нийцүүлнэ.

3.Ачаа тээвэрлэлтийг гүйцэтгэх тээврийн хэрэгслийн оврын хэмжээ, бүрэн жин, нэг тэнхлэг дээрх ачаалал нь тээвэрлэлт хийгдэж буй талын дотоодын хууль, техникийн холбогдох стандартад нийцсэн байна. Хоёр улсын техникийн холбогдох стандартын шаардлага харилцан адилгүй тохиолдолд хоёр Талын эрх бүхий байгууллага, эсхүл эрх олгогдсон байгууллага шийдвэрлэх арга замыг санаачлах бөгөөд энэ асуудлыг өөр, өөрийн Талын холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

4.Хэлэлцэн тохиролцогч аль нэг талд бүртгэлтэй ачааны тээврийн хэрэгсэл болон зүтгүүр нь хэлэлцэн тохиролцогч нөгөө Талд бүртгэлтэй, эсхүл гуравдагч улсад бүртгэлтэй хагас чиргүүлээр ачаа тээвэрлэлт гүйцэтгэж болно.

## 9 дүгээр зүйл

### Тээвэрлэлтийн хяналт, үйлчилгээ

1.Олон улсын авто замын тээвэрлэлт гүйцэтгэж буй хоёр талын жолооч нь энэхүү протоколын 6 дугаар зүйлд заасан холбогдох бичиг баримтыг биедээ болон тээврийн хэрэгсэлдээ авч явах бөгөөд хэлэлцээрийн 14 дүгээр зүйлд заасны дагуу хяналт, шалгалтад хамрагдана.

2.Хоёр улсын хилийн боомтын хяналт, шалгалт, хорио цээрийн байгууллага хэлэлцээрийн 14 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг баримтлан зорчигчийн тогтмол тээврийн хэрэгсэлд эхний ээлжид үзлэг, шалгалт хийнэ

3.Хэлэлцэн тохиролцогч нэг Талын жолооч болон тээврийн хэрэгсэл хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт зам тээврийн осолд орох. тээврийн хэрэгсэл эвдэрч саатвал тухайн талын эрх олгогдсон байгууллагад хандан туслалцаа авах хүсэлт гаргаж болно. Тухайн Талын эрх олгогдсон байгууллага нь шаардлагатай туслалцааг цаг тухайд нь үзүүлнэ.

4.Хэлэлцэн тохиролцогч нэг Талын жолооч болон тээврийн хэрэгсэл хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт зам тээврийн осол гаргасан тухай мэдээллийг тухайн Талын эрх олгогдсон байгууллага хүлээн авмагц шаардлагатай тусламжийг нэн даруй үзүүлж, энэ талаар нөгөө Талын эрх

олгогдсон байгууллагад яаралтай мэдээлнэ. Зам тээврийн ослоос үүдсэн асуудлыг осол гарсан Талын дотоодын хууль тогтоомж болон холбогдох бусад журмын дагуу шийдвэрлэнэ. Хэрэв осол гаргаад зугтаасан тохиолдолд хоёр талын холбогдох байгууллагууд хамтран ажиллаж, асуудлыг нэн даруй шийдвэрлэнэ.

## 10 дугаар зүйл

### Мэдээлэл солилцох

1.Хэлэлцэн тохиролцогч Талуудын эрх бүхий байгууллага, эсхүл эрх олгогдсон байгууллага өөрийн улсын авто замын тээвэртэй холбоотой хамаарах хууль тогтоомж, стандартад оруулсан өөрчлөлтийн талаар тухай бүр харилцан мэдээлж байна.

2.Хоёр Талын эрх олгогдсон байгууллага нь өөрийн улсын олон улсын авто замын тээвэрлэлт гүйцэтгэж буй тээвэрлэгч, тэдгээрийн тээврийн хэрэгсэл, тээвэрлэсэн ачаа, зорчигчийн тоо хэмжээ, зөвшөөрлийн бичгийн олголт, ашиглалт, хяналт, тээврийн хэрэгслийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл болон нөгөө Талын тээвэрлэгч хэлэлцээр болон протоколын заалтыг зөрчсөн байдал зэрэг мэдээллийг улирал тутамд харилцан солилцож байна.

3.Хэлэлцэн тохиролцогч хоёр Талын эрх бүхий байгууллага, эсхүл эрх олгогдсон байгууллага улс хооронд тээвэрлэлт эрхлэгч аж ахуйн нэгж, жолооч болон тээврийн хэрэгслийн мэдээллийн сан байгуулан тогтмол хугацаанд холбогдох мэдээллийг солилцож, өөрийн улсын холбогдох байгууллагыг мэдээллээр хангана.

## 11 дүгээр зүйл

### Бусад

1.Хэлэлцээр болон энэхүү протоколоор зохицуулаагүй бусад асуудлыг хоёр улсын хооронд байгуулсан бусад хэлэлцээр болон өөр өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

2.Талууд энэхүү протоколд харилцан тохиролцсоны үндсэн дээр хэдийд ч нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Оруулсан нэмэлт, өөрчлөлт нь протоколын салшгүй хэсэг болох бөгөөд тухайн нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болох хэлбэр, хүчинтэй байх хугацаа нь энэхүү протоколтой адил байна.


3.Энэхүү протоколд гарын үсэг зурснаас хойш ... оны ... дүгээр сарын ....-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд түүний хүчинтэй хугацаа нь хэлэлцээрийн хүчинтэй хугацаатай адил байна.

4.Энэхүү протокол хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Бээжин хотноо байгуулсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын автотээврийн хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яам

болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Зам тээврийн яам хоорондын протокол хүчингүй болно.

Энэхүү протоколыг 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр Бээжин хотноо монгол, хятад, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдэж, гарын үсэг зурсан бөгөөд эх бичвэр бүр адил хүчинтэй байна. Хэрвээ орчуулгын зөрүү гарвал англи хэл дээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМЫГ  
ТӨЛӨӨЛЖ:



.....

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД  
АРД УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМЫГ  
ТӨЛӨӨЛЖ



.....



МОНГОЛ УЛС,  
БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН  
ХООРОНД ОЛОН УЛСЫН ТЭЭВЭР ХИЙХ АВТОМАШИНЫ ЗОРЧИХ  
ЗӨВШӨӨРЛИЙН БИЧИГ

蒙 古 国  
中 华 人 民 共 和 国  
国 际 汽 车 运 输 行 车 许 可 证

MGL

Монгол Улсын Зам,  
тээврийн хөгжлийн  
яам

蒙古国

交通运输部

Хүчинтэй хугацаа 2024 оны 01  
сарын 01-ний өдрөөс 2025 оны 01  
сарын 31-ний өдөр хүртэл  
有效期自 2024 年 1 月 1 日至  
2025 年 1 月 31 日。  
Дугаар 编号: 0000001

CHN

БНХАУ-ын Зам,  
тээврийн яам

中华人民共和国  
交通运输部

A

Энэхүү зорчих зөвшөөрлийг улс хоорондын зорчигчдын тогтмол тээвэр хийхэд хэрэглэнэ. Олон удаа хил нэвтрэхэд хүчинтэй.

本行车许可证用于国际道路定期旅客运输，多次往返有效。

1. Тээвэрлэгч байгууллагын нэр болон хаяг:  
承运人名称及注册地址:

2. Автомашины улсын дугаар:  
汽车牌照:

3. Автомашины марк:  
汽车型号:

4. Суудлын тоо:  
核定载客:

5. Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа  
行车许可证有效期

自 年 月 日至 年 月 日止

6. Тээврийн маршрут  
运输线路

Эхний起点: Дундын途径:  
Эцсийн (ирж, буцах)/ 终点 (往返):

7. Нэвтрэх хилийн боомт  
出入境口岸

Гарах боомт出境: Орох боомт入境:

8. Монголын талын зөвшөөрөл  
олгосон байгууллагын тамга:  
蒙方发证机关盖章:

9. Хятадын талын эрх олгогдсон  
Байгууллагын тамга, албан тушаалтны  
гарын үсэг, зөвшөөрөл олгосон он сар өдөр:  
中方受权机构盖章, 负责人签字, 发证日期:

МОНГОЛ УЛС,  
БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН  
ХООРОНД ОЛОН УЛСЫН ТЭЭВЭР ХИЙХ АВТОМАШИНЫ ЗОРЧИХ  
ЗӨВШӨӨРЛИЙН БИЧИГ

蒙古 古 国  
中 华 人 民 共 和 国  
国际汽车运输行车许可证

MGL

Монгол Улсын Зам,  
Тээврийн хөгжлийн

яам

蒙古国

交通运输部

Хүчинтэй хугацаа 2024 оны 01  
сарын 01-ний өдрөөс 2025 оны 01  
сарын 31-ний өдөр хүртэл  
有效期自 2024 年 1 月 1 日至  
2025 年 1 月 31 日。  
Дугаар 编号: 0000001

CHN

БНХАУ-ын Зам,  
Тээврийн яам

中华人民共和国

交通运输部

B

Энэхүү зорчих зөвшөөрлийг улс хоорондын зорчигчдын тогтмол бус тээвэр хийхэд хэрэглэнэ.  
Олгосон өдрөөс 30 хоногийн хугацаанд нэг удаа хил нэвтрэхэд хүчинтэй.

本行车许可证用于国际道路不定期旅客运输, 自签发之日起 30 日内一次往返有效。

1. Тээвэрлэгч байгууллагын нэр болон хаяг:

承运人名称及注册地址:

2. Автомашины улсын дугаар:  
汽车牌照:

3. Автомашины марк:  
汽车型号:

4. Суудлын тоо:  
核定载客:

5. Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа  
行车许可证有效期

自 年 月 日 起 至 年 月 日 止

6. Тээврийн маршрут  
运输线路

Эхний起点: Дундын途径:

Эцсийн(ирж буцах)终点 (往返):

7. Нэвтрэх хилийн боомт  
出入境口岸

Гарах боомт出境:

Орох боомт入境:

8. Монголын талын зөвшөөрөл  
олгосон байгууллагын тамга:

9. Хятадын талын эрх олгогдсон

байгууллагын тамга, албан тушаалтны

гарын үсэг, зөвшөөрөл олгосон он сар өдөр:

中方授权机构盖章, 负责人签字, 发证日期:

蒙方发证机关盖章:

МОНГОЛ УЛС,  
БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН  
ХООРОНД ОЛОН УЛСЫН ТЭЭВЭР ХИЙХ АВТОМАШИНЫ ЗОРЧИХ  
ЗӨВШӨӨРЛИЙН БИЧИГ

蒙 古 国  
中 华 人 民 共 和 国  
国 际 汽 车 运 输 行 车 许 可 证

MGL

Монгол Улсын Зам,  
Тээврийн хөгжлийн

яам

蒙古国

交通运输部

Хүчинтэй хугацаа 2024 оны 01  
сарын 01-ний өдрөөс 2025 оны 01  
сарын 31-ний өдөр хүртэл  
有效期自 2024 年 1 月 1 日至  
2025 年 1 月 31 日。  
Дугаар 编号: 0000001

CHN

БНХАУ-ын Зам,  
Тээврийн яам

中华人民共和国

交通运输部

C

Энэхүү зөвшөөрлийг улс хоорондын байнгын ачаа тээвэр хийхэд хэрэглэнэ. Олгосон өдрөөс 120 хоногийн хугацаанд олон удаа хил нэвтрэхэд хүчинтэй.

本行车许可证用于国际道路长期货物运输, 自签发之日起 120 日内多次往返有效。

1. Тээвэрлэгч байгууллагын нэр болон хаяг:  
承运人名称及注册地址:

2. Автомашины улсын дугаар: 汽车牌照:	3. Автомашины марк: 汽车型号:	4. Зөвшөөрөгдсөн даацын хэмжээ 核定载重量:
--------------------------------------	------------------------------	---

5. Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа 行车许可证有效期	он сар өдрөөс 自 年 月 日至	он сар өдөр хүртэл 年 月 日止
---	---------------------------	------------------------------

6. Тээврийн маршрут 运输线路	Эхний起点: Дундын途径: Эцсийн(ирж буцах) 终点 (往返):
-----------------------------	--

7. Нэвтрэх хилийн боомт 出入境口岸	Гарах боомт出境: Орох боомт入境:
----------------------------------	------------------------------

8. Монголын талын зөвшөөрөл олгосон байгууллагын тамга: 蒙方发证机关盖章:	9. Хятадын талын эрх олгогдсон байгууллагын тамга, албан тушаалтны гарын үсэг, зөвшөөрөл олгосон он сар өдөр: 中方受权机构盖章, 负责人签字, 发证日期:
---	---

МОНГОЛ УЛС,  
БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН  
ХООРОНД ОЛОН УЛСЫН ТЭЭВЭР ХИЙХ АВТОМАШИНЫ ЗОРЧИХ  
ЗӨВШӨӨРЛИЙН БИЧИГ

蒙 古 国  
中 华 人 民 共 和 国  
国 际 汽 车 运 输 行 车 许 可 证

MGL

Монгол Улсын Зам,

Тээврийн хөгжлийн

яам

蒙古国

交通运输部

Хүчинтэй хугацаа 2024 оны 01  
сарын 01-ний өдрөөс 2025 оны 01  
сарын 31-ний өдөр хүртэл  
有效期自 2024 年 1 月 1 日至  
2025 年 1 月 31 日。

Дугаар 编号: 0000001

CHN

БНХАУ-ын Зам,

Тээврийн яам

中华人民共和国

交通运输部

D

Энэхүү зорчих зөвшөөрөл нь ачааг түр хугацаагаар тээвэрлэхэд ашигладаг бөгөөд олгосон өдрөөс хойш 30 хоногийн дотор нэг удаа тээвэрлэхэд хүчинтэй байна.

本行车许可证用于临时双边货物运输, 自签发之日起 30 日内一次往返有效。

1. Тээвэрлэгч байгууллагын нэр болон хаяг:  
承运人注册地址:

2. Автомашины улсын дугаар:  
汽车牌照:

3. Автомашины марк:  
汽车型号:

4. Зөвшөөрөгдсөн даацын  
хэмжээ  
核定载重量:

5. Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа  
行车许可证有效期

自 年 月 日至 年 月 日

6. Тээврийн маршрут  
运输线路

Эхний起点: Дундын途径:  
Эцсийн(ирж буцах) 终点 (往返):

7. Нэвтрэх хилийн боомт  
出入境口岸

Гарах боомт出境: Орох боомт入境:

9. Монголын талын зөвшөөрөл  
олгосон байгууллагын тамга:  
蒙方发证机关盖章:

10. Хятадын талын эрх олгогдсон  
байгууллагын тамга, албан тушаалтны  
гарын үсэг, зөвшөөрөл олгосон он сар өдөр:  
中方受权机构盖章, 负责人, 签字发证日期:

МОНГОЛ УЛС,  
БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН  
ХООРОНД ОЛОН УЛСЫН ТЭЭВЭР ХИЙХ АВТОМАШИНЫ ЗОРЧИХ  
ЗӨВШӨӨРЛИЙН БИЧИГ

蒙 古 国  
中 华 人 民 共 和 国  
国 际 汽 车 运 输 行 车 许 可 证

MGL

Монгол Улсын Зам,  
тээврийн хөгжлийн

яам

蒙古国

交通运输部

Хүчинтэй хугацаа 2024 оны 01  
сарын 01-ний өдрөөс 2025 оны 01  
сарын 31-ний өдөр хүртэл  
有效期自 2024 年 1 月 1 日至  
2025 年 1 月 31 日。  
Дугаар 编号: 0000001

CHN

БНХАУ-ын Зам,  
тээврийн яам

中华人民共和国

交通运输部

G

Энэхүү зорчих зөвшөөрөл нь гуравдагч орны ачааг түр хугацаагаар тээвэрлэхэд зориулагдсан бөгөөд олгосон өдрөөс хойш 60 хоногийн дотор нэг удаа хоёр талын аялалд хүчинтэй байна.

本行车许可证用于临时第三国货物运输，自签发之日起 60 日内一次往返有效。

1. Тээвэрлэгч байгууллагын нэр болон хаяг:

承运人名称及注册地址:

2. Автомашины улсын дугаар:  
汽车牌照:

3. Автомашины марк:  
汽车型号:

4. Зөвшөөрөгдсөн даацын  
хэмжээ 核定载重量:

5. Зөвшөөрлийн хүчинтэй  
хугацаа 行车许可证有效期

自 年 月 日 至 年 月 日  
он сар өдрөөс он сар өдөр хүртэл  
自 年 月 日至 年 月 日止

6. Ачаа ачих улс/ачаа буулгах газар  
装 货国/卸货地:

7. Ачаа буулгах улс/ачаа ачих газар  
卸货国/装货地:

8. Автомашины  
Маршрут 运输线路

Эхний起点: Дундын途径: Эцсийн终点:

9. Нэвтрэх хилийн боомт  
出入境口岸

①

②

10. Монголын талын зөвшөөрөл олгосон  
байгууллагын тамга:  
蒙方发证机关盖章:

11. Хятадын талын эрх олгогдсон  
байгууллагын тамга, албан тушаалтны  
гарын үсэг зөвшөөрөл олгосон он сар өдөр:  
中方受权机构盖章, 负责人签字, 发证日期:

МОНГОЛ УЛС,  
БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН  
ХООРОНД ОЛОН УЛСЫН ТЭЭВЭР ХИЙХ АВТОМАШИНЫ ЗОРЧИХ  
ЗӨВШӨӨРЛИЙН БИЧИГ

蒙古 古 国  
中 华 人 民 共 和 国  
国 际 汽 车 运 输 行 车 许 可 证

MGL

Монгол Улсын Зам,  
Тээврийн хөгжлийн  
яам

蒙古国

交通运输部

Хүчинтэй хугацаа 2024 оны 01  
сарын 01-ний өдрөөс 2025 оны 01  
сарын 31-ний өдөр хүртэл  
有效期自 2024 年 1 月 1 日至  
2025 年 1 月 31 日。  
Дугаар 编号: 0000001

CHN

БНХАУ-ын Зам,  
Тээврийн яам

中华人民共和国

交通运输部

Н

Энэхүү зорчих зөвшөөрөл нь түр хугацаагаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэхэд ашигладаг бөгөөд олгосон өдрөөс хойш 30 хоногийн дотор нэг удаа хоёр талын аялалд хүчинтэй байна.

本行车许可证用于临时过境货物运输，自签发之日起 30 日内一次往返有效。

1. Тээвэрлэгч байгууллагын нэр болон хаяг:

承运人名称及注册地址:

2. Автомашины улсын дугаар:  
汽车牌照:

3. Автомашины марк:  
汽车型号:

4. Зөвшөөрөгдсөн даацын  
хэмжээ: 核定载重量:

5. Зөвшөөрлийн хүчинтэй  
хугацаа 行车许可证有效期

自 年 月 日至 年 月 日止

6. Ачаа ачих улс/Ачаа буух газар  
货国/卸货地:

装 7. Ачаа буух улс/Ачаа ачих газар  
卸货国/装货地:

8. Тээврийн  
Маршрут  
运输线路

Эхний起点: Дундын途径: Эцсийн终点:

9. Нэвтрэх хилийн  
боомт 出入境口  
岸

①  
②

10. Монголын талын зөвшөөрөл олгосон  
байгууллагын тамга:  
蒙方发证机关盖章:

11. Хятадын талын эрх олгогдсон  
байгууллагын тамга, албан тушаалтны  
гарын үсэг зөвшөөрөл олгосон он сар өдөр:  
中方受权机构盖章, 负责人签字, 发证日期:

МОНГОЛ УЛС,  
БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН  
ХООРОНД ОЛОН УЛСЫН ТЭЭВЭР ХИЙХ АВТОМАШИНЫ ЗОРЧИХ  
ЗӨВШӨӨРЛИЙН БИЧИГ

蒙 古 国  
中 华 人 民 共 和 国  
国 际 汽 车 运 输 行 车 许 可 证

MGL

Монгол Улсын Зам,  
тээврийн хөгжлийн  
яам

蒙古国

交通运输部

Хүчинтэй хугацаа 2024 оны 01  
сарын 01-ний өдрөөс 2025 оны 01  
сарын 31-ний өдөр хүртэл  
有效期自 2024 年 1 月 1 日至  
2025 年 1 月 31 日。  
Дугаар 编号: 0000001

CHN

БНХАУ-ын Зам,  
тээврийн яам

中华人民共和国

交通运输部

E

Энэхүү онцгой зөвшөөрлийг ачаатай болон ачаагүй автомашины оврын хэмжээ, бүх жин болон нэг тэнхлэг дээрх ачаалал нь нөгөө талын дотоодын хууль тогтоомж, техникийн стандартад заасан хэмжээнээс хэтэрсэн, мөн ачаа тээвэрлэлтийн стандартад заасан хэмжээнээс хэтэрсэн задалж болдоггүй ачааг улс хооронд тээвэрлэхэд хэрэглэнэ. Нэг удаа хил нэвтрэхэд хүчинтэй.

本种《特别行车许可证》用于缔约一方外廓尺寸、轴荷及最大允许载质量超出运输发生地所在国法律法规和技术标准规定限值且不可解体的货物运输车辆，一次往返有效。

1. Тээвэрлэгч байгууллагын нэр болон хаяг:  
承运人名称及注册地址:

2. Автомашины улсын дугаар:  
汽车牌照:

3. Автомашины марк:  
汽车型号:

4. Зөвшөөрөгдсөн даацын  
хэмжээ 核定载重量:

5. Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа  
行车许可证有效期

自 年 月 日 至 年 月 日  
он сар өдрөөс он сар өдөр хүртэл

6. Тээврийн маршрут  
运输线路

Эхний起点: Дундын 途径:  
Эцсийн(ирж буцах)终点 (往返):

7. Нэвтрэх хилийн боомт  
出入境口岸

Гарах боомт出境: Орох боомт 入境:

8. Монголын талын зөвшөөрөл  
олгосон байгууллагын тамга,  
蒙方发证机关盖章:

9. Хятадын талын эрх олгогдсон  
байгууллагын тамга, албан тушаалтны  
гарын үсэг зөвшөөрөл олгосон он сар өдөр:  
中方受权机构盖章, 负责人签字, 发证日期:

МОНГОЛ УЛС,  
БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН  
ХООРОНД ОЛОН УЛСЫН ТЭЭВЭР ХИЙХ АВТОМАШИНЫ ЗОРЧИХ  
ЗӨВШӨӨРЛИЙН БИЧИГ

蒙 古 国  
中 华 人 民 共 和 国  
国 际 汽 车 运 输 行 车 许 可 证

MGL

Монгол Улсын Зам,  
тээврийн хөгжлийн

яам

蒙古国

交通运输部

Хүчинтэй хугацаа 2024 оны 01  
сарын 01-ний өдрөөс 2025 оны 01  
сарын 31-ний өдөр хүртэл  
有效期自 2024 年 1 月 1 日至  
2025 年 1 月 31 日。  
Дугаар 编号: 0000001

CHN

БНХАУ-ын Зам,  
тээврийн яам

中华人民共和国  
交通运输部

F

Энэхүү онцгой зөвшөөрлийг улс хоорондын аюултай ачаа тээвэр хийхэд хэрэглэнэ.  
Нэг удаа хилээр нэвтрэхэд хүчинтэй.

本特别行车许可证用于国际道路危险货物运输，一次往返有效。

1. Тээвэрлэгч байгууллагын нэр болон хаяг:  
承运人名称及注册地址:

3. Автомашины улсын дугаар:  
汽车牌照:

4. Автомашины марк:  
汽车型号:

5. Зөвшөөрөгдсөн даацын  
хэмжээ  
核定载重量:

6. Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа  
行车许可证有效期

自 年 月 日至 年 月 日止

7. Тээврийн маршрут  
运输线路

Эхний起点: Дундын途径:  
Эцсийн(ирж буцах)终点 (往返):

8. 出入境口岸  
Нэвтрэх хилийн боомт

出境/Гарах боомт/: 入境/Орох боомт/:

9. Монголын талын зөвшөөрөл  
олгосон байгууллагын тамга:  
蒙方发证机关盖章:

10. Хятадын талын эрх олгогдсон  
байгууллагын тамга, албан тушаалтны  
гарын үсэг зөвшөөрөл олгосон он сар өдөр:  
中方授权机构盖章, 负责人签字, 发证日期:



МОНГОЛ УЛС,  
БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН  
ХООРОНД ОЛОН УЛСЫН ТЭЭВЭР ХИЙХ АВТОМАШИНЫ ЗОРЧИХ  
ЗӨВШӨӨРЛИЙН БИЧИГ

蒙 古 国  
中 华 人 民 共 和 国  
国 际 汽 车 运 输 行 车 许 可 证

MGL

Монгол Улсын Зам,  
ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН

ЯАМ

蒙古国

交通运输部

Хүчинтэй хугацаа 2024 оны 01  
сарын 01-ний өдрөөс 2025 оны 01  
сарын 31-ний өдөр хүртэл.  
有效期自 2024 年 1 月 1 日至  
2025 年 1 月 31 日。  
Дугаар 编号: 0000001

CHN

БНХАУ-ын Зам,  
ТЭЭВРИЙН ЯАМ

中华人民共和国

交通运输部

A-C

Энэхүү зорчих зөвшөөрлийг улс хоорондын зорчигчдын тогтмол тээвэр гүйцэтгэж байгаа автомашиныг дагалдан зорчигчдын ачааг чингэлэгтэй автомашинаар тээвэрлэхэд хэрэглэнэ. Олон удаа хил нэвтрэхэд хүчинтэй.

本行车许可证用于跟随国际道路定期旅客运输班车的密封厢式行包货物运输，多次往返有效。

1. Тээвэрлэгч байгууллагын нэр болон хаяг:  
承运人名称及注册地址:

3. Автомашины улсын  
дугаар:  
汽车牌照:

4. Автомашины  
марк:  
汽车型号:

5. Зөвшөөрөгдсөн даацын  
хэмжээ  
核定载重量:

6. Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа  
行车许可证有效期

自 年 月 日 至 年 月 日  
он сар өдрөөс он сар өдөр хүртэл

7. Тээврийн маршрут  
运输线路

Эхний起点: Дундын途径:  
Эцсийн(ирж буцах) 终点(往返):

8. Нэвтрэх хилийн боомт  
出入境口岸

Гарах боомт出境: Орох боомт入境:

9. Монголын талын зөвшөөрөл  
олгосон байгууллагын тамга:  
蒙方发证机关盖章:

10. Хятадын талын эрх олгогдсон  
байгууллагын тамга, албан тушаалтны  
гарын үсэг, зөвшөөрөл олгосон он сар өдөр:  
中方受权机构盖章, 负责人签字, 发证日期:

**ОЛОН УЛСЫН АВТОЗАМЫН ТЭЭВЭРЛЭЛТИЙН  
АЧААНЫ ДАГАЛДАХ БИЧИГ  
国际道路货物运单**

№:000001

1. Илгээгч Нэр _____ Улс _____ 1. 发货人 名称 _____ 国家 _____		2. Хүлээн авагч нэр _____ Улс _____ 2. 收货人 名称 _____ 国家 _____			
3. Ачааг ачих газар Улс _____ Хот _____ Гудамж _____ 3. 装货地点 国家 _____ 市 _____ 街道 _____		4. Ачааг буулгах газар улс _____ хот _____ Гудамж _____ 4. 卸货地点 国家 _____ 市 _____ 街道 _____			
5. Ачааны тэмдэг ба дугаар 5. 货物标记和号码	6. Тоо ширхэг 6. 件数	7. Баглаа боодлын төрөл зүйл 7. 包装种类	8. Ачааны нэр 8. 货物名称	9. Эзлэхүүн (м³) 9. 体积(m³)	10. Бүх жин (кг) 10. 毛重(kg)
11. Илгээгчийн зааврууд 11. 发货人指示					
a. Орох/Гарах зөвшөөрлийн бичгийн дугаар: _____ -аас _____ хүртэл _____ боомтын Гааль a. 进出口许可证号码: _____ 从 _____ 到 _____ 口岸海关					
b. Ачааны өртөгийн илэрхийлэл b. 货物声明价值					
c. Илгээгчийн дагалдуулсан бичиг баримтууд c. 发货人随附单证					
d. Захиалгын бичиг буюу гэрээний дугаар d. 订单或合同号		тээврийн зардал болон бараа тушаах газрыг багтаана 包括运费, 交货点			
e. Бусад зааврууд e. 其他指示		тээврийн зардал болон бараа тушаах газрыг багтаахгүй 不包括运费, 交货点			
12. Тээвэрлэлтийн онцгой нөхцөл 12. 运送特殊条件		13. төөгөөлөөл-эхнэж Заавал төлөх тээврийн зардал 13. 应付运费			
		Илгээгч 发货人	Тээврийн зардал 运费	Мөнгийн төрөл зүйл 币别	Хүлээн авагч 收货人
14. Тээвэрлэгчийн санал 14. 承运人意见					
15. Тээвэрлэгч 15. 承运人		Нийт 共计			
16. Үйлдсэн өдөр хугацаа Ачааг тээвэрлэгчид шилжүүлсэн _____ цаг _____ минут Ачаа хөдөлсөн _____ цаг _____ минут Илгээгчийн гарын үсэг, тамга _____ Тээвэрлэгчийн гарын үсэг, тамга _____ 16. 编制日期 到达装货 _____ 时 _____ 分 离去 _____ 时 _____ 分 发货人签字盖章 _____ 承运人签字盖章 _____		17. Тус ачаа дагалдах бичгийг хүлээн авсан өдөр хугацаа _____ 17. 收到本运单货物日期: _____ 18. Ачааг хүргэж очсон _____ цаг _____ минут ачаа буцсан _____ цаг _____ минут Хүлээн авагчийн гарын үсэг, тамга _____ 18. 到达卸货 _____ 时 _____ 分 离去 _____ 时 _____ 分 收货人签字盖章 _____			
19. Автомашинны улсын дугаар _____ даац багтаамж _____ Жолоочийн овог нэр _____ чиргүүлийн улсын дугаар _____ Зөвшөөрлийн бичгийн дугаар _____ Ачааны дагалдах бичгийн дугаар _____ 19. 汽车牌号 _____ 车辆吨位 _____ 司机姓名 _____ 拖挂车号 _____ 行车许可证号 _____ 路单号 _____		20. Тээврийн зай _____ хил нэвтрэх зай _____ Хүлээн авагчийн хил доторхи зорчих зай _____ нийт _____ 20. 运输里程 _____ 过境里程 _____ 收货人境内里程 _____ 共计 _____			
21. Гаалийн байгууллагын тэмдэглэл: 21. 海关机构记载:		22. Хүлээн авагчийн дурдах боломж бүхий санал: 22. 收货人可能提出的意见:			

Заавар: 1. Тус бичгийг Монгол хэлээр болон харгалзсан бусад улсын хэлээр хэвлэн үйлдэж хэрэглэнэ .

2. Тус бичгийг энгийн байдалд нэг хэвийн дүрвэн хуудсаар хэрэглэнэ. Нэгдүгээр хуудсыг үлдээнэ . Хоёрдугаар хуудсыг эхний өртөөний гаалийн газарт , гуравдугаар хуудсыг боомтын гаалийн газарт тус тус тушаана. Дүрвэдүгээр хуудсыг жолоочид гардуулна. (хэрэв дамжин өнгөрөх тээвэр бол , 6-8 хуудас

үйлдэж дамжин өнгөрөх гаалийн газарт үлдээхэд бэлтгэнэ ) .

说明：1. 本运单使用中文和相应国家文字印刷。

2. 本运单一般使用一式四联单。第一联：存根；第二联：始发地海关；第三联：口岸地海关；第四联：随车携带  
(如是过境运输可印制 6-8 联的运单，供过境海关留存)。

Монгол Улсын Олон Улсын Автозамын Зорчигч тээврийн зорчих замын хуудасны үлдэх хувь  
 蒙古国际道路运输旅客运输存根  
 Дугаар 编号 №

Монгол Улсын Олон Улсын Автозамын Зорчигч тээврийн зорчих замын хуудас  
 蒙古国际道路运输旅客运输存根  
 Дугаар 编号 №

Тээвэрлэгч байгууллага 运输单位: Тээврийн хэрэгслийн улсын дугаар 车号: Жолоочийн овог нэр 驾驶员姓名:  
 Тээврийн маршрут 运输线路: Эхний буудал 始点: Дундын буудал 经: Эцсийн буудал 终点:

Тээвэрлэгч байгууллага 运输 单位	Эхний зогсоол 始点站		Нэвтрэх боомт 过港口岸		Эцсийн зогсоол 终点站		Зорчигчийн тоо / хүн/ 旅客人数	Ачааны тоо /ширхэг/ 行包数量	Ачааны жин /тонн/ 行包重量 /吨/	Аяллын зай / км/ 行驶里程 /公里/
	Улс	Буудлын нэр	Гарсан боомт	Орсон боомт	Улс	Буудлын нэр				
Автогээрлийн зөвшөөрлийн дугаар 道路运输 证号码										
Жолоочийн овог, нэр 驾驶员姓名										
Тээврийн хэрэгслийн улсын дугаар 车 号										
Машины марк 车 型										
Тээврийн шугам 运输线路										
Зорчигчийн тоо 旅客人数										
Тээвэрлэгчийн зай 运距										
Хүчинтэй хугацаа 有效期	Замын хуульцасны хүчинтэй хугацаа 路单有效期		.....оны .....сарын .....өдрөөс .....оны .....сарын .....өдрийг хүртэл 从 .....年 .....月 .....日起至 .....年 .....月 .....日							
Олгосон этгээд 签发人	Эрх бүхий байгууллагын тамга 主管机关(章)		Олгосон байгууллага /тамга/ 签发机关(章)		Олгосон этгээд 签发人				Буцааж авсан этгээд 回收人	
Тээвэрлэгч этгээд 领用人	Тэмдэглэл: 1. Энэхүү замын хуудыг 1 удаа ашиглана. 2. Энэ хувь тээврийн хэрэгслийг дагалдана. Хэрэглэсний дараа заасан хугацаанд олгосон байгууллагад буцааж өгнө. 备注: 1. 本路单一次性使用; 2. 此联随车携带, 使用后按期交签发机关。									





**CHN**

The image features a logo consisting of the letters 'M', 'G', and 'L' in a bold, black, sans-serif font. These letters are arranged vertically and are enclosed within a thin black oval border. The background is plain white.

**MGL**